

ТҮҮХ, ЭДИЙН ЗАСАГ

Д. Маам

түүхийн ухааны дэд эрдэмтэн

**АМЕРИК-ХЯТАД-ЯПОНЫ ГУРАМСАН ХАРИЛЦААНЫ
МӨН ЧАНАР**

Тавиад оны сүүл хагасаас маогийнхан ЗХУ, коммунист ажилчны хөдөлгөөнийг сэргөж, уул хөдөлгөөнд дайсагнах чиг шугам баримтлан гарч ирсэн үед АНУ-БНХАУ-ын харилцаанд шинэ үе тэмдгэрсэн юм. Америкийн хэвлэлд «Коммунист Хятад» гэж нэрлэдэг улсын удирдлагад Мао Зедун нарын их хятадын дээрэнгүй үзэл бодолтой, ленинизмд дайсагнасан, жижиг хөрөнгөтний бүлэг зонхилж байсныг ялангуяа Даманы хэрэг явдлаас хойш ултай мэдэхдээ Пентагон дараах шатны зохих дүгнэлт хийсэн байна.¹ Гэвч америкийн империализм өрөөсгөлөөр Хятад руу гар сунгасан биш. ЗХУ-д дайсагнах явдлыг туг болгосон Хятадын удирдагчид ч зөвлөлтийн эсрэг үзлээрээ бардамнан Пентагонд ая тал засч америкийн империализмтэй ойртох замыг сонгожээ.

Маоизм хичнээн зүүний царай гаргаж байлаа ч баруун тийш хэлбийх, тэр ч байтугай империализмтэй хэлхэлдэх аюултай байгааг бүр 1964 оны хоёрдугаар сард ЗХУКН-ын Төв Хорооны бүгд хурал анхааруулан тэмдэглэж байсан юм. М. А. Суслов бүгд хуралд тавьсан илтгэлдээ: Зөвлөлтийн коммунистууд маогийнхан Хятадыг ямар аюултай замруу хөтөлж байгаа бол хэмээн сэтгэл түгшиж байна гэж мэдэгдсэн билээ.²

1978 онд АНУ, Хятадын хооронд дипломат харилцаа тогтов. Энэ бол олон улсын харилцааны хэвийн үзэгдэл болох жирийн нэг дипломат харилцаа тогтсон нь биш, хоёр талын цэрэг-улс төрийн бодлогын үүднээс зайлшгүй шаардлагатай нь дахин давтан нотлогдсон агаад социализм энхийн үйл хэргийг ноцтой сэргөсөн хамтын бодит арга хэмжээ байв.

АНУ, Хятад Ард улс хоёр эхэн хирдээ дэлхийн олон нийтийн нүднээс далдуур, сүүл сүүлдээ илээр сүлбээлдэн, ЗХУ-ыг улайран дайсагнах, социализм, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг үзэн ядаж эсэргүцэх замаар, тэгэхдээ зэрэгцсэн хоёр фронтын маягаар дэлхийн жанжлалын төлөө тэмцэж эхэлсэн дараах үе шат 70-аад оны сүүл хүртэл үргэлжлэв. Удалгүй америк, хятадын удирдагчид өөр хоорондоо өрсөлдөөн тэмцэлтэй боловч социализмд гол нь энхийн манлай хүч ЗХУ-д дайсагнасан нэгэн зорилго бүхий зэрэгцсэн үйл ажиллагаагаа нэгтгэн зохицуулах замд шилжжээ. Америк-Хятадын харилцаанд сүлбээлдээн гүнзгийрч улмаар цэрэг стратегийн холбоотны шинж чанар ажиглагдах нь олширч, сүүлдээ энэ хандлага зонхилох төлөвийг олов.

Эдүгээ явагдаж буй уг үе шатны мөн чанар нь империалист-маоист хэтийн төлөвлөгөөний үндсэн дээр хоёр улс улам бүр ойртон нягтарч, чухамдаа цэрэг-улс төрийн холбоо байгуулах, уг холбоонд Японыг татан

¹"The China quarterly" 1980, 82-p 337

²М. А. Суслов. Избранное.Речи и статьи. М., 1972. с. 382.

оролцуулах бодлогыг хэрэгжүүлж эхэлснээр тодорхойлогдож байна. Өөрөөр хэлбэл ЗХУ ба социализмд дайсагнасан америк, хятадын зэрэгцээ фронт, эдийн засгийн буурьтай нөөц бүхий³ японы милитаризмыг хамтран нэгтгэх байдлаар нэгэн фронт болж өрөгсөн гүнзгийрэх үйл явц зарим талаар хэрэгжин боловсорч байгаа юм. Энэ тухай н. Ю.Цэдэнбал «...ЗХУ болон азийн социалист бусад орнуудын эсрэг шууд чиглэсэн АНУ-хятад японы цэрэг улс төрийн гурамсан түрэмгий холбоо үнэн хэрэгтээ бүрэлдэн тогтлоо»⁴ гэж МАХН-ын ТХ-ны III бүгд хурал дээр заан тэмдэглэсэн билээ.

Америк-Хятад-японы харилцааны энэхүү суулийн үе шатны онцлог нь бүх нийтийн аюулгүй байдалд заналхийлсэн хэт идэвхжилтэй байдлаар тодорхойлогдож байна. Нэг талаас америкийн цэрэгжсэн империализмыг цөмийн шинэ зэвсгээр дахин зэвсэглэх Рейганий засаг захиргааны дайнч бодлого, нөгөө талаас «дөрвөн шинэчлэл» хэмээх милитарист төлөвлөгөө АНУ, БНХАУ-д ойролцоогоор нэгэн үед хэрэгжиж эхэлсэнтэй дээрх онцлог зарим байдлаар нөхцөлдөн гарч ирсэн нь бодитой хэрэг юм. Гэвч хоёр орны харилцааны иймэрхүү хэт идэвхижилттэй байдлын үндсэнд тохиолдлын буюу цаг зуурын бус, хариу олон улсын харилцааны түүхийн тодорхой шалтгаан оршиж буйг тэмдэглэхгүй өнгөрч болохгүй. Тодруулбал америкийн империализм, хятадын маоизмын ангийн язгуур мөн чанараас урган гарсан «ЗХУ-ыг бүслэх» дэлхийн бодит социализмыг нэгдсэн хүчээр дайсагнах алс хэтийн стратеги хоёр орны харилцаанд үндэс болсоор ирснийг өгүүлэлтэй. Америк, Хятадын ойртолтын хүчин зүйлүүд субъектив бус бодитой цаг зуурын бус хэтийн хандлагатай гэдгийг уул харилцааны өнгөрсөн түүхээс гадна одоогийн үе шатны онцлог болох дээр өгүүлсэн цэрэг-улс төрийн хэт идэвхжилтэй байдал нотолж байна. Хятадын эдийн засгийг капитализмчилах бодлого Америкийн засаг захиргаа, японы милитарист бүлгийн Хятадтай гурамсан холбоо байгуулах стратегийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болж байгааг социалист орнуудын хэвлэл ажиглан тэмдэглэсээр ирлээ. Нөгөө талаас хятадын удирдагчид гадаадын капиталын хувьд «нээлттэй хаалгын» бодлого явуулж харин дотооддоо эдийн засгийн ерөнхий хямралыг гэтлэн давах зам бол улсын төсөвт зардлыг нэгэн хэмжээнд барьж царцаах тэрч байтугай хасаж тонох зам мөн гэж үзэж байгаа нь бүрч ноцтой хэрэг юм. Одоо Хятадад 1949 оны ардын хувьсгалаар тавигдсан эдийн засгийн социалист суурь хятадын нийгмийн маоист давхрага, америк, японы голлосон гадаадын капиталын нэгдсэн довтолгоонд хэлмэгдэх үйл явц эхлээд байгаа нь эндээс тодорхой болж байна.

Мао Зэдун 1940-өөд онд Нанкин хотноо АНУ-ын элчин сайдын яамны ажилтантай ярилцахдаа засгийн эрхийг авсны дараа «...эдийн засгийн системийн хувьд Америкийг дууриан хуулбарлах бодолтой» байгаагаа баяр хөөртэй тэмдэглэж байжээ.⁷ Их гүрний дээрэнгүйлэл, жижиг хөрөнгөтний эрх ашгийг илэрхийлэгч Маогийн энэ үг санамсаргүй буюу Америкаас зэвсэг техник олох гэж манжилж ярьсан яриа биш болохыг 1947 онд хуралдсан ХКН-ын VII их хурал тухайн үедээ баталсан

³Япон улс бүр 70-аад оны эхэн гэхэд дайны дараах эдийн засгийн хөгжил нь жигдрэн хангагдаж, капиталист ертөнцөд АНУ-ын дараа хоёрдугаар байрыг-баттай эзлэх болсон байна. (Д. В. Петров. Япония в мировом политикс М.. 1973 с. 3)

⁴«Үнэн». 1981. 12. 3.

⁵«Үнэн». 1982—1—26.

⁷Федор Бурлацкий. Мао Цэдун: наш коронный номер-это война и диктатура. М., 1976 г.

билээ. Мао Зэдуны үзэл санаа намын жанжин шугамыг орлож чадах онцгой хүчин зүйл мэтээр өргөж тавьсан тэр их хурлын шийдвэрт: «...хувьсгалаас явуулах арга хэмжээ нь хувийн аж ахуйг устгахад чиглэгдэх биш, харин хувийн аж ахуйг хамгаалахад чиглэгдэнэ. Энэхүү хувьсгалын явцад капитализм хөгжих зам цэвэрлэгдэх ёстой!⁸ гэж дурьджээ. Энэ бүхнийг хятадын одоогийн удирдагчдын эдийн засгийн чиг шугам («Жэнминь жибао» 1981. 11. 1), гадаад түшиглэл, холбоотны бодлоготой харьцуулан үзэхэд ам сүүл хоёр нийлж байна бус уу?! гэдэг асуулт гарч ирж байна.

Ингээд бид америк-хятадын харилцааны одоо үеийн байдлыг товч авч үзье.

Рейган ерөнхийлөгчийн сонгуулийн үед улс төрийн өрсөлдөгчдөө гутаах зорилгоор Хятадтай хүзүү сээрээ нийлүүлж, Цагаан хэрмийн дотор талд их хэмжээний үргүй зардал хаях нь америкийн үндсэний эрх ашигт харш явдал: «АНУ-ын эд хөрөнгө гэж тийм ч шавхагдашгүй зүйл байдаг бусаа»⁹ гэх зэргээр мэдэгдэж байлаа. 1981 оны зургадугаар сарын 14-17-нд Рейганы толгойлсон америкийн шинэ засаг захиргааны төрийн нарийн бичгийн дарга Александр Хейг Бээжинд айлчлалт хийв. Энэ бол Рейганыхан Цагаан ордонд орсныхоо дараа Хятадтай хамтран явуулсан анхны томоохон дипломат үйл ажиллагаа байсан юм. АНУ-ын ерөнхийлөгчид нэр дэвшигдмэгцээ Хятадтай хэт ойртохыг буруушаан, болгоомжилж байсан Рейган, ерөнхийлөгч болчихоод чухам ямар бодлого баримтлах вэ гэдэг асуултын хариуг Хятадын удирдагчидтай А. Хейгийн хийх хэлэлцээ дэлхийн олон нийтэд өгөх ёстой байсан бөгөөд өгсөн юм. Хятад, Америкийн хооронд тогтсон цэрэг-улс төрийн хэлхээ холбоог бодитойгоор шатлан өргөжүүлэх явдал Хейгийн айлчлалтын үндсэн зорилго байсан нь удаан хүлээлгэлгүйгээр нотлогдлоо. Хоёр орны удирдагчид «стратегийн үүднээс нэгэн ерөнхий ашиг сонирхолтой байна»¹⁰ гэдгээ яаран мэдэгджээ. Үүгээр сонгуулийн өмнөх ба хойтох үеийн Рейганы ам ажил хоёр хойшид ноцтой зөрөх нь харагдсан боловч дээрх мэдэгдэл бүхэлдээ тийм ч их хачирхал төрүүлэх зүйл биш байлаа. Учир нь 1980 он, 1981 оны эхний саруудад Америк Хятадын удирдагчдын харилцааны шинэ үе шатны үндэс үнэн хэрэгтээ нэгэнт тавигдаад байсан бөгөөд үүнийг Рейган ч удалгүй талархалтайгаар зөвшөөрөн хүлээсэн билээ.

Рейганы тэргүүлсэн шинэ засаг захиргааг Цагаан ордонд иртэл өгүүлэн бүхий харилцааны хөгжил хэрхэн явагдаж ирснийг баримтаар авч үзье. АНУ-ын батлан хамгаалах яамны сайд агсан Г. Браун 1980 оны нэгдүгээр сард Картерын засаг захиргааг төлөөлөн Хятадад ирээд хоёр орны хэлхээ холбос «Хэтийн шинж чанартай» гэдгийг гоцлон тэм-дэглэж байлаа. Браун, түүний хятад түнш нар, ялангуяа Дэн Сяопин, Гэн Бяо нар «стратегийн эрх ашиг нийцэж байгаагаа», «дипломатын хүрээнд төдийгүй батлан хамгаалах салбарт хэн хэнийгээ тэтгэн дэмжсэн ажиллагаанд шилжиж болох талтай байна» гэдгийг нийтэд зориулж мэдэгдсэн билээ.¹¹ Энэхүү өдөөн турхирсан мэдэгдлийг Хятад, АНУ-ын албаны хүмүүс, сонин хэвлэл яаралтай шүүрэн авч, Зөвлөлтийн эсрэг үзүүрийг нь хурцлан суртал нэвтрүүлгийн өргөн кампанидаа ашигласан юм. «Жэньминь жибао» сснин «Дэлхийн дахины страрегийн шаардлагыг

⁸История Китая (с древнейших времен до наших дни), М. 1974 г с 392.

⁹«Прочлемы Дальшто Востока» 1981 г. 3 с. 71

¹⁰«Үнэн» 1982-1-6.

¹¹«Крисчен Сайнс Монитор» сонины сурвалжлагчийн чуулганд Дэн Сяопины өгсөн хариулт «Проблемы Дальнего Восгока» сэтгүүлийн 1981. № 3-аас дамжуулж иш татлаа. (Профессор М. 3 Украинцовын өгүүлэл)

харгалзан авч үзэж»,¹² харилцааг гүнзгий хийгээд өргөн цараатай, батлан хамгаалах шинж чанартай болгохыг хятадын олон нийт, Америкийн засаг захиргаанд удаа дараа эрээ цээргүй уриалж эхлэв. Америкийн нэрт тоймч Ж. Храфт, Хятадад зэр зэвсэг худалдах талаар АНУ-ын өндөр хэмжээний албаны хүмүүсийн дунд гарсан үг яриаг ишлэн дурьдаад «АНУ-ын тухайд ЗХУ-ын эсрэг тэмцэх гол холбоотон нь Хятад болж хувирлаа»¹³ гэж «Вашингтон пост» сонинд бичжээ.

Ингэж ЗХУ-ын эсрэг дэлхийн бүх хүчнийг нэгтгэх уриан дор 1974 онд НҮБ-ын индрээс Дэн Сяопины тунхагласан хийгээд америкийн империализмтэй холбоо тогтоох явдлыг «онол»-ын хувьд зөвтгөсөн төдийгүй зайлшгүй мэтээр авч үзсэн «Мао Зэдуны гурван ертөнцийн онол» гэгч, улс түмний аюулгүй байдалд дайсагнасан онц ноцтой бодит байдалд хувирч зарим талаар хэрэгжих шатанд орсон байна. Дашрамд өгүүлэхэд «Гурван ертөнцийн онол»-ыг сэдэгчид Хятадыг «Гурав дахь ертөнцийн» орнууд буюу хөгжиж байгаа орнуудтай нэг зиндаанд тавьж, тэдгээр орныг нэн түрүүнд нэгдэж болох хүч гэж үзсэн боловч үнэн хэрэг дээрээ Америк, Японы дайнч бүлэглэлтэй «нэн түрүүнд нэгдэж» тэд өөрсдөө үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнд дайсагнагч гэдгээ нотлов. Маоизмын ангийн чанарын тухай бидний дээр тэмдэглэснийг энэхүү баримт давхар нотолж байгаа гэж үзэлтэй.

Америкийн империализм, Хятад дахь маоизмын харилцааны хамгийн онцлог шинж бол уул харилцаа зөвлөлтийн эсрэг үзэлд суурилсан явдал болох нь тодорхой. Нөгөөтэйгүүр бүр анхнаасаа америк-хятадын ойртолтын үйл явц зэвсэг техникийн салбарт ажиглагдам хүчтэй хөгжиж ирснийг хэлэх хэрэгтэй бөгөөд энэ бол өгүүлэн бүхий харилцааны хоёр дахь ноцтой шинж чанар юм. Чухам цэрэг зэвсгийн салбар дахь хамтын ажиллагааны тухайд ярьж байгаад Александр Хейг хоёр орны хоорондын харилцаа «яг одоо үеийнх шиг хэзээ ч ийм ойр дотно байгаагүй»¹⁴ гэж хүлээн зөвшөөрсөн нь санамсаргүй хэрэг биш.

Цэрэг-зэвсгийн салбарт Бээжин Вашингтон хэрхэн ойртож түншилсэн үйл явцыг тун товчоор улируулан авч үзвэл, 1972 онд америкийн «РКА» пүүз маогийнхны гадаад худалдааны байгууллагатай 5,7 сая долларын хэлэлцээр байгуулж теледүрс дамжуулах хоёр дагуулыг Хятадад нийлүүлжээ. Яг энэ үеэр Хятадын армийн албан хаагчдаас зонхилон бүрдсэн 200 гаруй нисгэгч онгоцны техникчдийг дадлага хийлгэхээр Бээжин, Вашингтонд мордуулжээ.¹⁵

70-аад оны эхэн үеийн АНУ, БНХАУ-ын харилцаа 1973 онд холбоо хэлхээ тогтоох төлөөлөгчдийн газар гэгчийг Вашингтон, Бээжинд харилцан байгуулснаар тодорхой нэгэн шатанд гарч түр зуурын сааталд орсон юм. Форд америкийн ерөнхийлөгч байсан 70-аад оны дунд үеэр цэрэг зэвсгийн салбарт хамтран ажиллах дээрх хандлага нилээд нарийсан гүнзгийрсэнийг нэхэн тэмдэглэвэл зохилтой.

АНУ-ын гадаад албаны дээд байгууллага болох Төрийн департамент «Контрол дейти» кампанид «Сайбер-172» хэмээх тооцоолон бодох машиныг ажиллуулах бүх хэрэгсэл, сэлбэгийг нь хамт хятадад худалдаалад зөвшөөрөл нууцаар олгосон нь 1976 оны арван хоёрдугаар сард илэрсэн ажээ.¹⁶ 1977 оны зун Пентагоны дээд зиндаанд цөмийн реактор, лазерын хэрэгслэл нисдэг тэрэг, танк эсэргүүцэх залуурт сум зэрэг нэн

Тухайлан «Жэньминь жибао» 1981—2—26-ны дугаарыг үзнэ үү.

«Вашингтон пост» 1981—2—3.

«Красная звезда», 13 сентября. 1981 г.

«Международная жизнь» № 8, 1981 г, с. 33.

«Международная жизнь» № 8, 1981 г. с. 34.

сүүлийн үеийн америкийн зэр зэвсгийг Хятадад нийлүүлэх тухай өргөн маргаан явагдсаныг дэлхийн олон нийт «Нью-Йорк таймс» сонины нэгэн өгүүллээс олж мэдлээ.¹⁷ 1978 оны тавдугаар сард тухайн үед ерөнхийлөгчийн үндэсний аюулгүй байдлын асуудал эрхэлсэн зөвлөх агсан З. Бжезинскийг Бээжинд очих үеэр Африк, Ойрхи Дорнод, Азид явуулах үйл ажиллагааны тухайд хоёр орны ашиг сонирхол зэрэгцсэн гэдгийг Хятад, Америкийн удирдлага анх түрүү хэвлэлд мэдээлсэн юм. Америкийн империализм, Хятадын маоизмын харилцааг цэрэг-улс төрийн холбооны хэмжээнд хүргэх, Японыг уг холбоонд татан оролцуулах бодлого чухам энэ үеэс эхэлсэн гэж үзэх үндэстэй байна. Үүнийг бусад олон баримтын зэрэгцээ АНУ-д «Хүчтэй хятад хэрэгтэй» байна¹⁸ хэмээн Бжезинскийн чухам тэр үед хийсэн мэдэгдлийг Бээжин онцын талархалтайгаар угтсан явдал давхар нотолсон юм. ЗХУ-г хоёр фронтын дайнаар сүрдүүлэхийн тул¹⁹ Дорнодод «Хятад-Америк-Японы» холбоо тогтоох, Өрнөдөд НАТО-тай хамтран ажиллах номлолыг Хятадын удирдагчдаас Дэн Сяо-пин америкийн засаг захиргаанаас Бжезинский анх түрүү энэ үеэр дэвшүүлэн гаргажээ.²⁰

Хоёр орны харилцааг шинэ чиглэлээр хөгжүүлэхэд 1979 оны 8-р сард АНУ-ын дэд ерөнхийлөгч У. Мондейлын Хятадад зочилсон айлчлалт үзэгдэхүйц үүрэг гүйцэтгэсэн билээ. Ойрын 5 жилийн цэрэг эдийн засгийн хэлхээ холбоог санхүүжүүлэхийн тул 2 миллиард долларын зээл Хятадын засгийн газарт олгохоор тогтсон Картерын засаг захиргааны шийдвэрийг У. Мондейл Бээжинд дамжуулсан юм. Бээжин ондоо багтаж мөнөөх зээлээс тооцох замаар АНУ-аас «БОИНГ-747» хэмээх онц багтаамжтай тээврийн онгоц яаралтай авсан нь Америкийн зэвсэг техникийг хятад руу зөөхөд шаардлагатай урьдчилсан алхам байв. Дэд ерөнхийлөгч Хятадын аюулгүй байдлыг хангах хийгээд эдүгээ Хятадад явагдаж буй шинэчлэл АНУ-ын эрх ашигт дүүрэн нийцэж байна.²¹ гэх зэргээр мэдэгдсэнийг хятадын удирдагчид улс төрийн өндөр үнэ цэнэтэй үг болгон шүүрэн авсан ажээ. 1980 оны нэгдүгээр сарын 24-нд Америкийн конгресс Хятадыг «үлэмж таатай дэглэм бүхий» орны тоонд оруулах шийдвэр гаргаж Хятадаас АНУ-д худалдах бүх бараанд хөнгөлөлт үзүүлэх болсноо мэдэгджээ.²² Мөн оны гуравдугаар сард АНУ-ын төрийн департамент 81 тоот тогтоолоор БНХАУ-д 30 нэр төрлийн зэвсэг техник гаргаж худалдаалахыг өөрийн орны концерн, кампани, пүүсүүдэд зөвшөөрсөн байна.²³

Үүнээс хойш асар удалгүй цагаан ордны засаг захиргаа солигдож Рейганыхан Пентагоныг толгойлох болсон бөгөөд энэ үеийн хоёр орны харилцааны гол үзүүлэлт болох хятадын удирдагчидтай А. Хейгийн хийсэн хэлэлцээрийн тухайд бид нэгэнт тэмдэглэсэн билээ. Ерөнхийдөө 1979 оноос одоо хүртэлх хоёр орны харилцааны байдлын талаар Зөв-лөлтийн эсрэг үзэлтнүүдийн нэрт төлөөлөгч З. Бжезинскийн мэдэгдлийг Синьхуа хороо 1981 оны долдугаар сарын 19-нд нийтэлсэн нь анхаарууштай баримт юм. «Хятад-америкийн харилцаа дэлхий дахины стратегийн нөхцөл байдлыг хэрхэн үнэлэх асуудлаар»-Дэн Сяопин бидний санал нэгдэв. «Үнэн хэрэг дээрээ АНУ-Хятад-Япон-Баруун Европын нэгдмэл

¹⁷Мөн тэнд.

“Peking Review” п. 8. 1978. п. 21. п. 5

«Международная жизнь» № 8. 1981 г, с. 34

Мөн тэнд. К: Lieberthat. The strategic Tringle: Can the U.S. play the “China card” Khr: 1979, p: 30:

«Жэньминь жибао» 1979 оны 8-р сарын 28.

«Международная жизнь» № 8. 1981 г. с. 35

«Чжунгун Яньцзыю», 1980 г. № 5.

эвсэл үүсэн бүрэлдэж байгааг» бид яриандаа цохож тэмдэглэсэн²⁴ гэж З. Бжезинский тэгэхэд мэдэгджээ. «Энэ бол бодит байдал юм. Харин энэхүү бодит байдлыг улс дундын харилцаан дахь шинэ бөгөөд чухал зүйл хэмээн хүлээн зөвшөөрөх ёстой»²⁵ гэж америкийн төрийн зүтгэлтэн үгийнхээ эцэст Синьхуа хорооны сурвалжлагчид хэлсэн байна...»

Ингээд бид гурамсан харилцаанд Хятад-япон ба Америк-японы хамтын ажиллагааны гүйцэтгэж буй үүрэг холбогдлын талаар авч үзье.

Япон-хятадын харилцаа ер бусын хурдацтайгаар газар авч байгааг ажигласны үндсэн дээр: «Бээжин АНУ-г цэрэг-улс төрийн нэгдүгээр зэргийн түншээ гэж үздэг болсон бол Японыг хятадын эдийн засгийн гол түнш гэж тооцож байна»²⁶ хэмээн профессор М. З. Украинцевын хийсэн дүгнэлт зүйтэй болохыг сүүлийн үеийн олон баримт нотоллоо.

Эдийн засгийн бүтээн байгуулалтын хувьд япончуудаас «суралцах юм их байгаа» тухай Дэн Сяопин нэг бус удаа мэдэгдсэн билээ. Японы техник, ер зээлийн тусламжтайгаар ихэд хоцрогдсон эдийн засагтаа ахиц гаргаж, «зэвсгийн шинэчлэл» явуулах дорвитой материаллаг баазтай болох горьдлого Дэн Сяопины «Японы хөлд суух» тактикийн цаана нуугдаж байна.

1980 оны 5-р сард Японд Хуа Гофэний хийсэн айлчлалтын үеэр хоёр орны харилцааны хэтийн төлөвийг «тогтоох» оролдлого ялангуяа хятадын талаас нилээд шамдуу хийгдсэн болохыг дэлхийн олон орны хэвлэлд тэмдэглэсэн билээ. Эдийн засгийн салбар дахь хамтын ажиллагаагаа улам буурьтай өргөжүүлэх явдал Хуа-Судзуки нарын хэлэлцээний үндсэн агуулга байсан аж.²⁷

Шинжлэх ухаан техникийн салбарт Японтой хамтран ажиллах хэлэлцээрт Хуа Гофэн гарын үсэг зурсан юм. Мөн сайд нарын зөвлөлийн орлогчдын хэмжээний уулзалтыг Бээжин, Токиод ээлжлэн зохион байгуулж, хамтын ажиллагааны хамгийн өргөн хүрээтэй асуудлуудыг авч хэлэлцэж байхаар шийдвэрлэжээ.

Хятад-Японы худалдаа 1980 онд 9,4 млрд доллар болж урьд жилийнхээс олон хувиар өссөн бөгөөд өнөөдөр Япон улсын 40 том пүүс, 33 том банк Бээжинтэй боломжийн өргөн хүрээний худалдаа, зээл авлагын харилцаатай ажиллаж байгаа юм.

Хятадын жанжлагчид, америкийн империалистууд, Японы милитаристуудын бодож төлөвлөж байгаагаар Хятадыг ЗХУ-ын эсрэг хөндөлдөн зогсож чадах цэрэг-зэвсгийн хүчирхэг гүрэн болоход стратегийн бодлоготойгоор хятадад үзүүлэх Японы техник эдийн засгийн тусламж хэрэгтэй байгаа бөгөөд Япон улс далайд Зөвлөлтийн флотыг ноцтой сөргөх хүч болон, цэрэгжсэн «Наран улс» дахин төрөхөд АНУ гол үүргийг гүйцэтгэх ёстой ажээ.

АНУ-ын ерөнхийлөгч Рейган, Японы ерөнхий сайд Судзуки нар 1981 оны дундуур уулзахдаа хоёр орны харилцааг чухамдаа «цэрэгжлийн холбоо» юм гэж заан тэмдэглэж байлаа.²⁸

Үүнийг Америк-Японы аюулгүйн гэрээний цэрэг-улс төрийн агуулгыг гүнзгийрүүлж, уул гэрээг НАТО-гийн харгис эвсэлтэй нэгэн зиндааны болгох хэмээсэн ноцтой оролдлого гэхээс өөрөөр үнэлж болохгүй юм. Дээр өгүүлсэн уулзалтын дараа Вашингтоноос цэрэг дайны бэлтгэ-

²⁴ Синьхуа хорооны мэдээ. 1981 оны 7-р сарын 19.

²⁵ Мөн тэнд. Мөн: Бюллетень информации. АПН № 34 (523) сентябрь 1981 года.

²⁶ «Бюллетень информации» АПН, № 42 (531) Окт. 1981 г. с. 30

²⁷ «Бюллетень информации» АПН № 42 (531) Окт- 1981 г. с. 30

²⁸ «Бюллетень информации» АПН № 38 (527) сентябрь 1981 г. с. 6.

лээ хангахын тул Япон улс нэн түрүү юу юу хийвэл зохих ёстойг нарийвчлан зааварласан урт бичгийг Токиод ирүүлжээ. Энэ үеэс Рейганы засаг захиргаа Японы милитаристуудтай ойртон сүлбэлдэх замаар Япон улсыг цэрэг зэвсгийн хувьд өөрийгөө хамгаалах орон байсныг «шат ахиулж», Пентагоны цөмийн зэвсгийн талбар болгон хувиргахад чиглэгдсэн аюултай алхмуудыг хийсэн байна. Нөгөө талаас япончууд цэргийнхээ хүч, дайтах чадвар, орчин үеийн зэвсгийн нөөцөө нэмэгдүүлэхийн үүднээс шуурхай арга хэмжээ авсан бөгөөд гадаад орнуудын эсрэг «зэвсэг хэрэглэх» зохист төлөвлөгөө» гэгчийг Вашингтон Токиод нэгэн зэрэг боловсруулж эхэлсэн билээ. Уул төлөвлөгөөний дагуу Японоос 1700 км алс орших Номхон далайн баруун хойт эрэгт далайн цагдаагийн үүрэг гүйцэтгэх эрхийг Японы цэргийн нисэх хүчин, флотод олгохоор АНУ шийдвэрлэсэн юм. Мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар энэ нь Японы агаарын ба далайн зэвсэгт хүчнийг наад зах нь бүтэн хагас дахин нэмэгдүүлнэ гэсэн үг ажээ.²⁹ Нөгөө талаар Японы удирдах албаныхан найрсаг, сайн хөршийн харилцаа тогтоох хэмээсэн ЗХУ-ын саналыг үл ойшоон «Зөвлөлтийн аюул» гэгч зохиомол суртал нэвтрүүлгийг хөөрөгдөж, цэрэг дайнаар хэнээрхэн, зөвлөлтийн нутагт хомголзон шунаж, хонзогнолын кампани дэгдээсээр байгааг тэмдэглэвэл зохилтой.

ЗХУ-ыг улайран дайсагнасан АНУ, Хятад, Японы цэрэг-улс төрийн хамтын ажиллагааны хоёр дахь үзүүр Ази тивийн энхийг эрхэмлэгч орнуудын эсрэг чиглэж байна.³⁰ Энэтхэг улсад өмнө далайгаас Америкийн империализм, умартын хуурай газрын хилээс маогийнхны хятад заналхийлж уул орныг хоёр галын дунд барьж, дарамт үзүүлэх бодлого явуулсаар удлаа. 1981 онд хятадын зэвсэгт хүчин дунд зайны тусгалын олон пуужинг өөр бүс нутгаас Төвдөд яаралтай шилжүүлж, Энэтхэгийн гол гол хотыг хараачилан байрлуулсан хийгээд АНУ Энэтхэгийн далай дахь флотынхоо цэрэг зэвсгийн хүчийг үлэмж нэмэгдүүлж байгаа зэргийг энд жишээ болгон татаж болно.³¹

Хятадын маоист удирдагчид америкийн империализм, Японы милитаризмтай холбоо тогтоохын тул эх орныхоо салшгүй хэсэг болох Тайванийг ч үнэн хэрэгтээ золиосонд гаргахад хүрээд байна. Америкийн конгресс 1980 онд «Тайваньтай тогтоох шинэ харилцааны тухай 2479 тоот хууль» гэгчийг баталсан³² бөгөөд үүнд Хятадууд хөнгөн маягийн «эсэргүүцэл» илэрхийлсэн төдийгөөр өнгөрсөн юм. Нөгөө талаар Тайваньтай холбооны гэрээ бүхий АНУ-тай дипломат харилцаа тогтоосон нь дефактын хувьд төдийгүй, олон улсын хууль эрхийн үүднээс хоёр Хятад оршин тогтнож буйг маогийнхан өөрсдөө нэгэнт хүлээн зөвшөөрчээ гэсэн хэрэг билээ. Дашрамд, «хоёр хятадыг зэрэгцүүлэх» такти-кийг Америк биш, чухам Япон улс эхлэн хэрэгжүүлснийг тэмдэглэвээс сонирхолтой. 1972 оны 9-р сард Хятадтай дипломат харилцаа тогтоох үедээ Япон нь Тайваньтай «албан бус» гэгдэх боловч нилээдгүй өргөн хүрээний, олон талт хамтын ажиллагаа бүхий харилцаатай байжээ.³³ Хорь гаруй жилийн уламжлалтай энэхүү харилцаа одоо ч нүдэн балай чихэн дүлий болж суугаа хятадын маоист удирдагчдын хамар дор өрөгжин цараалсаар байгаа юм.

Америкийн империализм, Хятадын маоизмын тус бүрийн түүхэн замналаас товч эргэн санахад, цэрэг улс төрийн энэхүү харилцааны бүх

²⁹ «Красная звезда» 13 сентября 1981 г.

³⁰ Тухайлан «Международная жизнь» № 8, 1981 г. (США-Китай. Опаснын альянс)

³¹ «Красная звезда» 13 сентября 1982.

³² Мөн тэнд

³³ Мөн тэнд

нийтийн аюулгүй байдалд тэрслэн заналхийлсэн дайнч түрэмгий мөн чанар улам тод болж байна. АНУ Зөвлөлтийн эсрэг бүх хүчний ажил явууллагыг турхиран тэтгэж Вьетнамын эсрэг олон жилийн цуст түрэмгийлэл үйлдсэний дээр Ойрхи Дорнод дахь дайн, хямралын гол буруутан нь энэ орон болохыг дэлхий нийтээр мэднэ. Дэлхийн II дайнаас хойш Ази тивд цэрэг-дайны томоохон мөргөлдөөн 30 удаа гарсны 19 нь буюу 63% нь Хятадын маоист удирдагчдын их гүрний дээрэнгүйлэл, хавсарган нэгтгэх бодлогын уршгаар үүсжээ. Өөр нэг жишээ татвал, 1980 онд хятадууд Вьетнамын хилийн суурин, хилийн харуулыг 2500 удаа довтолсон³⁴ бол 1981 оны 7-р сарын сүүлийн хагаст зөвхөн 4 өдрийн турш Вьетнамын Лангшон мужийн хот тосгодыг хятадын хилийн цэрэг их буугаар 1000 гаруй удаа буудсан юм.

Маогийнхан өнөөдөр Хөрш орнуудынхаа хаяаг хадрахад бэлтгэж Хятадын одоогийн нутаг дэвсгэрээс илүү их хэмжээний нутаг дэвсгэрт хомголзон шунаж «газрын зураг зүйн түрэмгийлэлийнхээ» бай болгоод байгаа бол Америкийн засаг захиргаа «цөмийн хэсэгчилсэн дайны» номлол зохиож, дэлхийн бодит социализмыг устгахаар санаархаж байна.

Хятадад социализмын материаллаг бааз байгуулах үндсэн хөтөлбөрийг баталсан ХКН-ын VIII их хурал (1956) маогийнханы зүгээс социализмын үйл хэрэгт заналхийлж байсан аюулыг соргоогоор мэдрэн тусгаж гадаад түшиглэлийн асуудлыг нарийвчлан авч үзсэн юм. ЗХУ, социалист хамтын нөхөрлөл, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнтэй хамт явахаас ухарч, энэ хүчнүүдийг сөргөсөн чиг шугам баримталбал хятад оронд «Америк болон бусад империалист гүрнүүдийн ноёрхол зайлшгүй тогтож бид тусгаар тогтнолоо алдахад хүрэхсэн билээ»³⁵ хэмээн уул их хурлын тайлан илтгэлд заасныг энд тэмдэглэхэд сонирхолтой төдийгүй онц холбогдолтой байна.

xx xx xx

Хэдийгээр хятад-америк-японы гурамсан харилцааг их гүрний дээрэнгүйлэл, эзлэн түрэмгийлэх хэтийн бодлого, Зөвлөлтийн эсрэг улайрсан үзэл буюу чухамдаа империализм, маоизм, милитаризмын ангийн эрх ашиг чандмалан холбож байгаа боловч, уул харилцаанд гүн гүнзгий дотоод зөрчил, гэтлэн давахын аргагүй гадаад бэрхшээл сөрөн зогсож байна.

Энэ оны 3-р сарын сүүлчээр Зөвлөлтийн нам төрийн тэргүүн, ЗХУКН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга А. И. Брежнев Ташкентэд хэлсэн үгэндээ: «Бээжингийн эрх баригчид олон улсын тавцан дээр империалистүүдийн бодлоготой хүзүү холбож байгаа нь мэдээжийн социализмын эрх ашигт харшилж байгаа боловч Хятадад нийгмийн социалист байгуулал байгааг бид хэзээ ч үгүйсгэж байгаагүй, одоо ч үгүйсгээгүй байна»³⁶ гэж Хятадын асуудлаар зарчмын өндөр ач холбогдолтой мэдэгдэл хийсэн билээ. Өгүүлэн буй сэдэвтэй холбогдуулан Хятад дахь социалист байгуулал, маогийнхны гадаад түшиглэлийн асуудалд үндсэн бэрхшээл болж байна гэдгийг нэн тэргүүнд хэлэх хэрэгтэй.

Лондонгийн стратегийн судлалын хүрээлэнгийн 1981 оны тайланд Хятадын нэг дивизийг америкийн хамгийн орчин үеийн зэвсгээр зэвсэглэхэд 664 саяаас 1 млрд долларын хөрөнгө зарах хэрэгтэй болох бөгөөд Хятад улс 400 гаруй дивизтэй гэж заажээ.³⁷ Үүгээр үз-

«Проблемы Дальнего Востока» № 3 1981 г. с 60.

VIII съезд КПК, М, 1956.

«Үнэн», 1982 оны 3-р сарын 26.

«Красная звезда» 13 сент. 1981 г.

вэл «Дундат»-ын зэвсэгт хүчнийг орчин үеийн арми болгон шинэчлэхэд 300 миллиард доллар орох болж байна. Гэтэл энэ нь «Жэньминь жибао» сонины арга буюу хүлээн зөвшөөрснөөр «санхүү»-эдийн засгийн хувьд бодитой аюулын өмнө тулгараад байгаа»³⁸ Хятадын нийгмийг төсөөлөхийн аргагүй хүнд байдалд оруулах юм.

Нөгөө талаар гурамсан харилцаа Америк, Японы хүн ардын зүгээс онц хүчтэй эсэргүүцэлтэй тулгарч байгааг дурьдалтай. Бүр 1980 оны 4-р сард америкийн «Бизнес уик» сэтгүүл «Хятадууд биднийг хэзээ нэгэн цагт эдүгээ оросуудыг хэрхэн үзэн ядаж байгаа шигээ үзэн ядах болно гэдгийг санах хэрэгтэй...тэд хэт нь манай анд нөхөд байх болно хэмээн гэнэн хонгорхноор бодох аваас тун тэнэг хэрэг болохсон билээ!»³⁹ гэж бичжээ.

Алсын хонжоо бодох Хятадад эдийн засгийн тусламж үзүүлэх гээд олон сая иений хохирол амсаж байгаа пүүсүүдийн байдлыг жишээ татаж Японы хэвлэл «Хятадын талаар хашир бөгөөд бодтой үнэлэлт өгөх хэрэгтэй болоод байна»⁴⁰ гэх мэтээр анхааруулан заадаг боллоо. «Хятадыг цэрэг-эдийн засгийн хувьд аюултай гүрэн болгож хувиргахгүйн тулд бололцоотой бүх арга хэмжээг урьдчилан авах хэрэгтэй»⁴¹ Энэ бол Японы олон улс судлалын хүрээлэнгээс нийтэлсэн «Хятадын талаархи Японы 80-аад онд баримтлах бодлого» гэсэн илтгэлийн гол дүгнэлт юм.

Эцэст гурамсан холбоо зохион байгуулахыг оролдогсодын үйл ажиллагааг таслан зогсоох гол хүч бол ЗХУ, бодит социализмын орнуудын нягтаар уялдан зохицолдсон энх тайванч гадаад бодлого, мөн энх тайвныг эрхэмлэгч энэ шийдвэрлэгч хүчний эсрэг тэмцэх замаар энх тайвныг сахин хамгаалж болохгүйг мэдэрч ойлгосон Азийн улс түмний хүчтэй эсэргүүцэл болж байна.

1982 оны 7-р сард А. А. Громыко, Александр Хейгийн БНХАУ-д айлчилсантай (1981 оны 6-р сар) холбогдуулан «Правда» сонинд бичсэн өгүүлэлдээ: «ЗХУ-д дайсагнах үндсэн дээр явагдаж байгаа америк-хятадын сүлбээлдээг бид АНУ ба Хятадтай харилцах харилцаа дээрээ тухайлан анхаарах болно. Хэрэг явдал хэрхэн эргэхээс хамаатан шаардагдах бүх арга хэмжээг ЗХУ шийдвэртэйгээр авах бөгөөд зөвлөлт төр өөрийгөө болоод өөрийн холбоотон, анд нөхдөө хамгаалан бат нот зогсож чадна гэдэгт хэн ч эс эргэлзвэл зохино.»⁴² хэмээн тэмдэглэсэн билээ.

³⁸ «Жэньминь жибао» 1981 оны 12 сарын 2, 14

³⁹ «Красная звезда» 13 сент. 1981 г.

⁴⁰ «Иомиури» 1980 оны 9-р сарын 15.

⁴¹ «Мэдээллийн сэтгүүл» 1982 он. № 2 18 дахь тал

⁴² «Правда» 1982 оны 7-р сарын 8.

СУЩНОСТЬ ТРОЙСТВЕННЫХ ОТНОШЕНИЙ МЕЖДУ США, КНР и ЯПОНИЕЙ.

Р е з ю м е

Последний период ознаменовался новым шагом маоистов на пути сближения с американским империализмом и японским милитаризмом.

В 1978 году между КНР и США были установлены дипломатические отношения. Этот шаг празительств обеих стран, к сожалению, нельзя рассматривать как обычное дипломатическое действие. Оно было продиктовано необходимостью милитаристской внешней политики двух стран и составило серьезную угрозу делу мира и безопасности. Сближение США и Китая на официальном уровне епче раз подтвердило истину, что правительство любой страны, пркдерживающееся антисоциалистического, антисоветского направления, рано или поздно, станет союзником империализма и реакции.

Настоящий период характеризовался еще более тесным сближением американского империализма и китайского гегемонизма, что нашло свое выражение в установлении союзных военно-политических связей. Серьез ную озабоченность вызывает вовлечение Японии в опасную игру против социализма, мира и безопасности в Азии. Тов. Ю.Цеденбал на III Пленуме ЦК МНРП особо подчеркнул, что: «фактически создается агрессивный военно-политический тройственный союз США-Китай-Япония, острие которого направлено прежде всего против Советского Союза и других азиатских стран социализма».

Политика «открытых дверей», проводимая Китаем в последнее время, является неотъемлемой частью общей стратегии создания союза с американским империализмом и японским милитаризмом. Подобная политика представляет серьезную опасность и для самого китайского народа.

Серьезным препятствием окончательному формированию этого опасного тройственного союза дслжны стать скоординированная внешняя политика социалистических стран, активные противодействия мировой общественности, прежде всего коллективные усилия азиатских стран.